

Агаарын тээвэр



Зорчигчид, мянган хүн
(давхардсан тоогоор)

2019 I-IX

1 262.3

2020* I-IX

393.4



Тээсэн ачаа,
тонн

4 285.1

1 936.9



Тээврийн орлого,
тэрбум төгрөг

408.9

120.7

Төмөр замын тээвэр



Зорчигчид, сая хүн
(давхардсан тоогоор)

2019 I-IX

2.2

2020* I-IX

1.6



Тээсэн ачаа,
сая тонн

20.5

22.1



Тээврийн орлого,
тэрбум төгрөг

525.1

575.5

Авто тээвэр



Зорчигчид, сая хүн
(давхардсан тоогоор)

2019 I-IX

127.9

2020* I-IX

98.0



Тээсэн ачаа,
сая тонн

30.4

17.8



Тээврийн орлого,
тэрбум төгрөг

571.8

350.5

*Урьдчилсан гүйцэтгэл



ТЭЭВЭР

Улсын хэмжээнд бүх төрлийн тээврээр 2020 оны эхний 9 сард 39.9 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 10.9 (21.4%) сая тонноор буурсан байна. Энэхүү бууралтад авто тээврээр тээсэн ачаа 12.6 (41.3%) сая тонноор буурсан нь голлон нөлөөлжээ.

Бүх төрлийн тээврээр 2020 оны эхний 9 сард 100.0 сая хүн (давхардсан тоогоор) зорчсон нь өмнөх оны мөн үеэс 31.3 (23.8%) сая хүнээр буурсан байна. Зорчигчдын тоо буурахад авто тээврээр зорчигчид 29.9 (23.4%) сая хүнээр буурсан нь голлон нөлөөлжээ.

Хүснэгт 46. Бүх төрлийн тээврийн үндсэн үзүүлэлт, жил бүрийн эхний 9 сарын байдлаар

Үзүүлэлт	2017 I-IX	2018 I-IX	2019 I-IX	2020* I-IX	
Тээсэн ачаа, сая тонн	40.1	48.7	50.8	39.9	Бүх төрлийн тээврээр тээсэн ачаа 2020 оны 3 дугаар улиралд өмнөх улирлаас 4.6 (36.2%) сая тонн, зорчигчид 5.5 (16.9%) сая хүнээр өсөж, тээсэн ачаа 17.1 сая тонн, зорчигчид 38.2 саяд хүрчээ байна.
Зорчигчид, сая хүн	158.1	145.0	131.3	100.0	
Тээврийн орлого, тэрбум төгрөг	1 082.9	1319.1	1506.3	1 046.7	

Бүх төрлийн тээврийн орлого 2020 оны эхний 9 сард 1046.7 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 459.7 (30.5%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

Авто тээврийн орлого 221.4 (38.7%) тэрбум төгрөг, агаарын тээврийн орлого 288.3 (70.5%) тэрбум төгрөгөөр тус тус буурсан нь бүх төрлийн тээврийн орлого буурахад нөлөөлсөн байна. Харин бүх төрлийн тээврийн орлого 2020 оны 3 дугаар улиралд, өмнөх улирлаас 83.0 (25.5%) тэрбум төгрөгөөр өсөж 408.9 тэрбум төгрөгт хүржээ.

АВТО ЗАМЫН ТЭЭВЭР

Авто тээврээр 2020 оны эхний 9 сард 17.8 сая тонн ачаа, давхардсан тоогоор 98.0 сая хүн тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс тээсэн ачаа 12.6 (41.3%) сая тонн, зорчигчид 30.0 (23.4%) сая хүнээр тус тус буурсан байна.

Ачаа тээврийн бууралтад уул уурхайн бүтээгдэхүүний тээвэр 10.3 сая тонн буюу 40.4 хувиар, зорчигч тээврийн хувьд нийслэлийн тээврээр зорчигчид (давхардсан тоо) 28.0 (24.1%) сая хүнээр буурсан нь нөлөөлсөн байна. Харин 2020 оны 3 дугаар улиралд, авто замын тээврээр тээсэн ачаа өмнөх улирлаас 4.1 (77.6%) сая тонн, зорчигчид 5.2 (16.1%) сая хүнээр өссөн байна.

Хүснэгт 47. Авто тээврийн үндсэн үзүүлэлт


Үзүүлэлт	2017 I-IX	2018 I-IX	2019 I-IX	2020* I-IX	
Тээсэн ачаа, сая тонн	23.8	30.0	30.4	17.8	Авто тээврийн салбарын орлого 2020 оны эхний 9 сард 350.5 тэрбум төгрөг болсон нь өмнөх оны мөн үеэс 221.4 (38.7%) тэрбум төгрөгөөр буурсан бол 2020 оны 3 дугаар улиралд 66.8 (67.5%) тэрбум төгрөгөөр өссөн байна.
Уул уурхайн бүтээгдэхүүн	20.3	25.5	25.5	15.2	
Зорчигчид, сая хүн	155.1	141.9	127.9	98.0	
Нийслэлийн нийтийн тээвэр	143.8	130.8	116.2	88.2	
Тээврийн орлого, тэрбум төгрөг	393.1	522.0	571.8	350.5	

Энд уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлтийн орлого өссөн нь голлон нөлөөлсөн байна.

ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВЭР

Төмөр замын тээврээр 2020 оны эхний 9 сард 22.1 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 1.7 (8.1%) сая тонноор өсжээ.

Зураг 74. Төмөр замын тээврээр тээсэн ачаа, мянган тонн, сараар



Төмөр замын тээврээр тээсэн ачааны өсөлтөд экспортын ачаа 1.4 (18.8%) сая тонн, дамжин өнгөрөх ачаа 258.4 (8.8%) мянган тонноор тус тус өссөн нь нөлөөлсөн байна.


Төмөр замын тээврээр тээсэн ачаа 2020 оны 9 дүгээр сард 2.7 сая тонн болж, өмнөх сараас 52.1 (2.0%) мянган тонноор өсжээ.

Хүснэгт 48. Төмөр замаар тээсэн ачаа, бүтээгдэхүүний бүлгээр, дүнд эзлэх хувиар

Үзүүлэлт	2018 I-IX	2019 I-IX	2020* I-IX
Бүгд	100.0	100.0	100.0
Уул уурхайн бүтээгдэхүүн	83.9	83.1	82.6
Барилгын материал	9.1	9.9	10.6
Мод, модон материал	0.6	0.6	0.5
Хүнсний өргөн хэрэглээний бүтээгдэхүүн	1.1	0.9	0.9
ХАА-н гаралтай бүтээгдэхүүн	0.9	1.3	0.8
Хар төмөр (хаягдал, рельс г.м)	1.0	1.4	1.8
Бусад	3.4	2.7	2.8

Төмөр замын тээврээр 2020 оны эхний 9 сард тээсэн нийт ачаанд уул уурхайн бүтээгдэхүүн 82.6 хувь, барилгын материал 10.6 хувь, хар төмөр 1.8 хувь, хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн 0.8 хувь, хүнсний өргөн хэрэглээний бүтээгдэхүүн 0.9 хувь, мод модон материал 0.5 хувь болон бусад бүтээгдэхүүн 2.8 хувийг эзэлж байна.

Зураг 75. Төмөр замын тээврээр зорчигчид, мянган хүн, сараар



Төмөр замын тээврээр 2020 оны эхний 9 сард 1.6 (давхардсан тоо) сая хүн зорчсон нь өмнөх оны мөн үеэс 522.5 (24.1%) мянган хүнээр буурсан байна.

Төмөр замын тээврээр зорчигчдын тоо буурахад орон нутгийн зорчигчид 438.2 (21.2%) мянган хүнээр буурсан нь нөлөөлсөн байна.

Төмөр замын тээврээр зорчигчид 2020 оны 9 дүгээр сард 225.7 мянган хүн болсон нь өмнөх сараас 55.9 (19.8%) мянган хүнээр буурчээ.


Төмөр замын тээврийн орлого 2020 оны эхний 9 сард 575.3 тэрбум төгрөг болсон нь өмнөх оны мөн үеэс 50.1 (9.5%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Энэ өсөлтөд уул уурхайн бүтээгдэхүүн, тухайлбал төмрийн хүдэр, цайрын баяжмалын тээвэрлэлт нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

Төмөр замын тээврийн орлого 2020 оны 9 дүгээр сард өмнөх сараас 3.2 (3.5%) тэрбум төгрөгөөр буурч, 67.7 тэрбум төгрөг болжээ.

АГААРЫН ТЭЭВЭР

Агаарын тээврээр 2020 оны эхний 9 сард 1.9 мянган тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 2.3 (54.8%) мянган тонноор буурсан байна.

Зураг 76. Агаарын тээврээр тээсэн ачаа, тонн, сараар




Агаарын тээврээр 2020 оны эхний 9 сард тоодод 59.3 (3.1%) тонн ачаа тээсэн нь өмнөх оны мөн үеэс 0.5 (0.8%) тонноор буурсан байна.

Мөн олон улсад тээсэн ачаа 1.9 (96.9%) мянган тонн болсон нь өмнөх оны мөн үеэс 2.3 (55.6%) мянган тонноор буурчээ.

Агаарын тээврээр тээсэн ачаа 2020 оны 9 дүгээр сард 169.5 тонн болж, өмнөх сараас 3.3 (2.0%) тонноор өссөн байна.

Зураг 77. Агаарын тээврээр зорчигчид, мянган хүн, сараар



Агаарын тээврээр 2020 оны эхний 9 сард давхардсан тоогоор 393.4 мянган хүн зорчсон нь өмнөх оны мөн үеэс 868.9 (68.8%) мянган хүнээр буурсан байна.

Агаарын тээврээр 2020 оны 9 дүгээр сард өмнөх сараас 2.1 (6.3%) мянган хүнээр бага буюу 31.0

мянган хүн зорчсон байна.

Агаарын тээврээр орон нутагт зорчигчид 2020 оны эхний 9 сард 241.3 (61.3%) мянган хүн болж, өмнөх оны мөн үеэс 88.1 (26.7%) мянган хүнээр буурсан байна. Энэхүү бууралтад Чойбалсан чиглэлийн зорчигчид 90.2 хувь, Овоот чиглэлийн зорчигчид 88.0 хувь, Мөрөн чиглэлийн зорчигчид 67.5 хувиар тус тус буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Агаарын тээврээр олон улсад зорчигчид 2020 оны эхний 9 сард 152.1 (38.7%) мянган хүн болж, өмнөх оны мөн үеэс 780.8 (83.7%) мянган хүнээр буурсан байна. Энэхүү бууралтад Улаанбаатар-Бээжин чиглэлийн зорчигчид 92.2 хувь, Улаанбаатар-Эрхүү чиглэлийн зорчигчид 89.7 хувь, Улаанбаатар-Москва чиглэлийн зорчигчид 88.0 хувь, Улаанбаатар-Хайлаар чиглэлийн зорчигчид 87.1 хувь, Улаанбаатар-Бусан чиглэлийн зорчигчид 87.1 хувиар буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Агаарын үндэсний тээвэрлэгчдийн орлого 2020 оны эхний 9 сард 120.7 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 288.3 (70.5%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

Агаарын үндэсний тээвэрлэгчдийн орлого 2020 оны 9 дүгээр сард өмнөх сараас 2.4 (19.3%) тэрбум төгрөгөөр буурч, 10.2 тэрбум төгрөг болсон байна.

